



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/᠒᠒.

Алтай хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх Эрдэнэ сумд бага оврын цэвэрлэх байгууламжийн угсралт, суурилуулалт, зүгшрүүлэлт, тохируулгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Хаш-Эрдэнэ (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Р.Цэнд-Аюуш (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ш.Батзүсэм (Хөндлөнгийн төлөөлөл)
(тохиролцсоноор)

Б.Галсанжамц (Есөнбулаг сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Л.Хаш-Эрдэнэ) -нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ